



*The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia*

Хэвлэлийн мэдээ

03.06.2019

Холбоо барих

+976 9511 7771

**АмЧам Монгол нь АНУ-аас Монгол Улсад сууж буй Элчин сайд  
Майкл С. Клеческигийн хөрөнгө оруулагчидтай хийх анхны уулзалтыг  
амжилттай зохион байгуулав**

УЛААНБААТАР, Монгол улс – Монгол дахь Америкийн Худалдааны Танхимын (АмЧам Монгол) зургадугаар сарын ээлжит Бизнес уулзалтыг 2019 оны 6-р сарын 3-ны өдөр Шангри-Ла зочид буудлын гол танхимд зохион байгуулж зочин илтгэгчээр АНУ-аас Монгол Улсад сууж буй Элчин сайд Майкл С. Клечески оролцов. Уулзалтын үеэр Элчин сайд Майкл С. Клечески Монгол улс, АНУ-ын хоёр талын харилцаа тэр дундаа худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх бодлогын талаар танилцуулж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай илэн далангуй санал солилцож, асуулт, хариултын хэлэлцүүлэг хийв. Уулзалтад АмЧамын гишүүн байгууллагууд, хувийн хэвшил, гадаадын элчин сайдын яамд оролцсон юм.

Элчин сайд Майкл С. Клечески АмЧам Монголын ачаар хувийн хэвшил болон худалдааны танхимын төлөөлөлтэй танилцсандаа баярлаж буйгаа онцлоод "Дэлхий даяар АмЧам нь АНУ-ын элчин сайдын яамтай нягт хамтран ажилладаг уламжлалтай," гэв. Ноён Клечески Монгол улс, АНУ-ын хоёр талын харилцааг хөгжүүлэх элчин сайдын яамны бодлогын талаар танилцуулж дараах тодорхой асуудлуудад төвлөрөн дэлгэрэнгүй ярив: Гуравдагч хөршийн худалдааны тухай хууль, Ил тод байдлын хэлэлцээр, Энхийг сахиулах үйл ажиллагаа, Хөрөнгө оруулалтын орчны тухай мэдэгдэл болон АмЧам Монголын АНУ руу хийх Бизнес айлчлал. Элчин сайд үргэлжүүлэн хэлэхдээ, "АНУ-Монгол Улсын бүхий л салбарын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх боломжууд байна. 2018-н онд хоёрт талын худалдаа өмнөх жилээсээ 47%-аар өсөж, нийт худалдааны эргэлт 121 сая ам. долларт хүрсэн. Гэвч 2011 онд 700 сая ам.доллар хүрч байсантай харьцуулбал бидэнд хийх ажил их байна. Энэхүү танхимд цугларсан хүн болгон энэхүү өсөлтөд хувь нэмрээ оруулах чадалтай болов уу. Уул уурхайн салбар нь Монгол улсын эдийн засгийн хамгийн чухал тулгуур бөгөөд уул уурхайн салбарын орлого улсын төсвийн 30%-ийг бүрдүүлдэг тул бидэнд аль болох олон Оюу Толгой байх тусам ашигтай. Төр, хувийн хэвшлийн түншлэлд төр засаг нь хэт их оролцож саад болохгүй байх нь зөв бөгөөд хувийн хэвшил нь улс орны эдийн засгийн хөгжил дэвшилд голлох үүрэгтэй байдаг."

АмЧам Монголын ТҮЗ-ийн дарга Ойбек Н. Халилов нээлтийн үгэндээ хэлэхдээ, "2017 онд Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, АНУ хоорондын гэрээнд хоёр улс гарын үсгээ зурсан. Ил тод байдлын хэлэлцээрийн дагуу олон улсын худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой хууль тогтоомжийн талаар олон нийтэд мэдээллэх, санал авах, хэвлэн нийтлэх, авлигатай тэмцэх зэрэг чиглэлээр харилцан мэдээлэл өгөх боломжийг бүрдүүлэх нь гадаадын хөрөнгө оруулалтыг татахад чухал ач холбогдолтой болно гэсэн үзэл санаатай энэхүү хэлэлцээрийг байгуулсан билээ. тод байдлын хэлэлцээрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хэрэгтэй байгааг онцлов.

Энэхүү хэлэлцээрийн бүрэн хэрэгжилтэд АмЧам Монгол өндөр ач холбогдол өгч ажиллаж байна" гэв. Элчин сайд Клечески санал нийлж хариулахдаа Монгол Улсад дараа жил болох Худалдаа ба хөрөнгө оруулалтын хэлэлцээрт бэлтгэж (Trade and Investment Framework Agreement), Монгол Улсын Засгийн газрын зүгээс Ил тод байдлын хэлэлцээрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хэрэгтэй байгааг онцлов.

Цаашид АНУ-ын Засгийн газар болон хувийн хэвшлийн санаа бодлыг Монгол Улсын Засгийн газарт хүргэж, хоёр улсын худалдааны харилцааг улам өргөжүүлж, худалдаа бизнесийн чиглэлд илүү амжилтыг бий болгохын төлөө ажиллах нь нэн чухал гэж энэхүү уулзалтаар дүгнэлээ.

### **АмЧам Монголын тухай**

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимиын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхimuудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхimuудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.